

**“АШИГТ МАЛТМАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”**

2018 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн “2019” гэснийг “2024” гэж өөрчилсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн танилцуулга

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль”-ийг батлан, 2011 оны 1 дүгээр сарын 1-нийг хүртэл мөрдөж, улмаар 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээ зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч 0-ээс 5 хүртэл хувьтай тэнцүү байхаар хуульчилсан.

Энэ арга хэмжээний үр дүнд 2012 онд 95 үйлдвэрээс 3,344.5 кг, 2013 онд 72 үйлдвэрээс 6,041.9 кг алт худалдан авсан нь өмнөх үеээс нэмэгдсэн боловч санасан хэмжээнд хүрэхгүй байсан тул төр засгаас онцгой анхаарч “Ашигт малтмалын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулан “Монголбанк түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээг 0 хувьтай тэнцүү” байхаар зааж 2014 оны 01 дүгээс сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнөөр 2014 оноос эхлэн алт худалдан авалт эрс өсч 2017 оны байдлаар Монгол банкинд тушаасан алтны хэмжээ 20 тоннд хүрсэн байна.

Мөн Засгийн газрын зүгээс алтны хайгуул, олборлолт, баяжуулалт, боловсруулалт, тушаалт зэргийг эрчимжүүлэх зорилгоор 1991 оны 304 дүгээр тогтоолоор “Алт хөтөлбөр” болон “Алт-2000 хөтөлбөр” (1992-2000) тус тус хэрэгжүүлж байсан бөгөөд үүний үр дүнд улсын хэмжээнд алтны олборлолт, экспорт эрчимтэй өсч, улсын төсвийн орлого болон гадаад валютын нөөц нэмэгдэж, тухайн үеийн эдийн засгийн хямралыг даван туулахад чухал хувь нэмрийг оруулж байсан.

“Алт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж хэлэхээс өмнө Монгол Улсын хэмжээнд жилд дундажаар 800кг алт олборлож байсан бол 1992 оноос эхлэн энэхүү хэмжээ огцом нэмэгдэж 1996 онд 7,5 дахин өсөн 5401 кг, 2005 онд 31,1 дахин өсч 24122 кг болжээ. Энэхүү үзүүлэлтээр Монгол Улс алт үйлдвэрлэлийн хэмжээгээр дэлхийд 19 дүгээр байрт орж байсан байна.

Хэдийгээр алт олборлолт манай улсын эдийн засагт нэг талаас эерэг нөлөө үзүүлсэн боловч нөгөө талаас далд эдийн засаг бий болох, байгаль орчныг бохирдуулах, нөхөн сэргээлтийг хангалтгүй хийх, хууль бусаар алт олборлох зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж байсан билээ. Засгийн газрын зүгээс дээрх урьд өмнө хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдийн эерэг үр дүн, сургамжид тулгуурлан “Ашигт малтмалын тухай” хуульд 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулж алтны нөөц ашигласны төлбөрийг 5 жилийн хугацаанд 2.5 хувь болгон өөрчилсний үр дүнд алтны үйлдвэрлэл нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд бодитоор өөрчлөлт үзүүлсэн.

Тухайлбал, Монгол банкинд тушаасан алтны хэмжээ 2014 онд 12.7 тонн, 2015 онд 15.1 тонн, 2016 онд 18.3 тонн, 2017 онд 20 тонн болж өссөн байна. Ашигт малтмалын тухай

хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.3. зүйлд орсон “Монголбанк, арилжааны банкинд худалдсан биет болон биет бус алтны нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү” гэх заалт 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болж байгаатай холбогдуулан алтны салбарын олборлолт, Монгол банк, түүнээс эрх олгосон банканд тушаах алтны хэмжээг бууруулахгүй татварын хувь, хэмжээг оновчтой болгох зорилгоор “Ашигт малтмалын тухай” хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа “Монголбанк, арилжааны банкинд худалдсан биет болон биет бус алтны нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувьтай тэнцүү” гэж тусгаж байгаа болно.

Судалгаанаас харахад сүүлийн жилүүдэд ойр ойрхон гарсан дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралын үед зарим улсын Засгийн газар, томоохон банк, санхүүгийн байгууллагууд алтыг их хэмжээгээр худалдан авч нөөцөлж, цаасан мөнгөний үнэгүйдэлээс хамгаалах болсон байна. Мөн алтны зах зээл дээрх үнэ богино хугацаанд бага зэрэг унаж байснаа эргээд өсөхдөө өмнөх үнээс илүү өсдөг байдал ажиглагдаж байна.

Манай Улсын хувьд 2005 онд нийт 24 тонн алт олборлож байсан бол 2012 онд 6 тонн болж 18 тонноор буурсан байна. Алтны дэлхийн зах зээлийн үнэ 2000 оноос хойшхи 13 жилд өсөлттэй байсан хэдий ч 2015 оныг хүртэлх 2 жилийн хугацаанд бууралт үзүүлсэн. 2000 онд 1 унц алтны үнэ Лондонгийн металлын бирж дээр 300 ам.доллар хүрэхгүй байсан бол 2006 онд 700 ам.доллар, 2008 онд 1000 ам.доллар, 2012 онд 1800 ам доллар болж 6 дахин өсч байсан бол 2018 оны байдлаар 1300 орчим ам долларын үнэтэй байна.

Хуулийн төслийг дээрх нөхцөл байдал болон өмнөх жилүүдийн алтны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ өндөр байх үеийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр боловсруулсан болно. Тухайлбал:

Алтны нөөц ашигласны төлбөр 5 хувиас дээш байх тохиолдолд алт олборлогч болон алт худалдан авагч хуулийн этгээдүүд алтыг хууль бусаар хил давуулан худалдах, олборлосон алтаа нуух, хадгалах, татвараас зайлсхийхийн тулд арилжааны банкинд тодорхой бус хугацаагаар барьцаалах зэрэг шудрага бус далд үйл ажиллагаа гарах хандлага ажиглагдаж байсан.

Түүнчлэн “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хийх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хүрээнд алтны шороон ордын нөөцийн үлдэгдэл 27.4 тн, үндсэн ордын нөөц 96.4 тн, нийт 123,8 тн алтны нөөцийг олборлох боломжгүй болсон байдаг байна.

Иймд алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн татварын дарамтыг зохистой хэмжээнд байлгах, Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, татварын суурийг өргөжүүлэх, борлуулсан алтанд ногдох орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх зорилгоор “Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар аж ахуй нэгж, иргэд хууль бусаар алт олборлох, алтыг зах зээлийн ханшнаас доогуур үнээр борлуулах, замаар татвараас зайлсхийх, тодорхой бус хугацаагаар арилжааны банкинд барьцаалах зэрэг далд үйл ажиллагаа хумигдаж

алтны олборлолт, борлуулалт ил тод, хуулийн хүрээнд явагдах боломж бүрдэж, алтны нөөцийн хэмжээ нэмэгдэж, улмаар гадаад валютын нөөц нэмэгдсэнээр эдийн засгийн баталгаа сайжирна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ